



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2023/130-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум 2023 он</p>	<p>ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.mn">bolort@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК Утас: 99102291 Цахим хаяг: <a href="mailto:Nitsbalance@gmail.com">Nitsbalance@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэлийн
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТЭЗ	Төсвийн ерөнхий захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.НАРАНГЭРЭЛ ТАНАА

2023.02.25 № 00А-2023/130-НА-СТА-ТЧУЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 95.8 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 46,893.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,400.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,267.7 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 7,586.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 4.2 хувиар хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 72.7 хувийг цалин хөлс, урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 10.6 хувийг байр

ашиглалттай холбоотой тогтмол зардал, 7.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,089,961.82</b>	<b>128,382,127.06</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		<b>84,837,860.67</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		84,837,860.67
3121	Төгрөг		84,837,860.67
31211	Төрийн сангийн харилцах		84,837,860.67
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>975,718.97</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		975,718.97
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>42,089,961.82</b>	<b>42,568,547.42</b>
<b>35100</b>	<b>ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛ</b>	<b>861,717.00</b>	<b>3,572,896.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	758,067.00	3,532,346.00
35130	Эм боох материал	103,650.00	40,550.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>41,228,244.82</b>	<b>38,995,651.42</b>
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	8,062,033.00	1,184,080.00
35450	Түлш, шатах тослох материал	92,810.00	
35460	Хүнсний материал	571,507.90	563,677.50
35470	Бусад хангамжийн зардал	32,501,893.92	37,247,893.92
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,116,746,091.64</b>	<b>4,225,787,534.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,116,746,091.64</b>	<b>4,225,787,534.23</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,104,912,758.24</b>	<b>4,214,390,200.79</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,212,100,000.00	4,352,100,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(298,357,082.88)	(368,558,749.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,122,572.91	201,634,448.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,093,178.15)	(92,169,739.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160,839,108.87	165,852,608.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,790,420.90)	(58,369,779.86)
39209	Бусад үндсэн хөрөнгө	7,997,000.00	7,997,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,798,800.08)	(4,398,200.16)
39211	Ном	4,893,558.47	10,302,612.79
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,833,333.40</b>	<b>11,397,333.44</b>
39301	Программ хангамж	2,180,000.00	2,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,346,666.60)	(1,782,666.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,000,000.00	11,000,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,158,836,053.46</b>	<b>4,354,169,661.29</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>19,442,031.24</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>19,442,031.24</b>
413	Өглөг		19,442,031.24

4136	Бусад өглөг		19,442,031.24
41361	Байгууллагад төлөх өглөг		19,442,031.24
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,158,836,053.46</b>	<b>4,334,727,630.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,158,836,053.46</b>	<b>4,334,727,630.05</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	11,000,000.00	11,000,000.00
51101	Өмч: -төрийн	11,000,000.00	11,000,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,147,836,053.46</b>	<b>4,323,727,630.05</b>
5121	Өмнөх үеийн үр дүн	4,147,836,053.46	4,147,836,053.46
5122	Тайлант үеийн үр дүн		175,891,576.59
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,158,836,053.46</b>	<b>4,354,169,661.29</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,430,712,645.37</b>	<b>6,234,511,671.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,643,777.66</b>	<b>4,228,218,006.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>19,643,777.66</b>	<b>4,228,218,006.05</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>19,643,777.66</b>	<b>7,334,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,746,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,588,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,540,907.66	4,171,598,134.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		49,285,871.82
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,411,068,867.71</b>	<b>2,006,293,665.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,201,799,300.00</b>	<b>1,732,629,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,732,629,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,201,799,300.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,913,917.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,753,917.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>187,355,650.71</b>	<b>273,663,865.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,355,650.71	273,663,865.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,501,150,700.83</b>	<b>1,994,083,097.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,501,150,700.83</b>	<b>1,994,083,097.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,473,047,047.42</b>	<b>1,862,635,776.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>965,439,112.59</b>	<b>1,246,400,275.02</b>
210101	Үндсэн цалин	621,084,685.48	957,850,977.26
210102	Нэмэгдэл	276,114,925.58	248,650,849.60
210104	Урамшуулал	68,239,501.53	39,898,448.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>128,803,459.00</b>	<b>155,251,921.34</b>

210201	Тэтгэврийн даатгал	90,059,507.00	106,469,332.75
210202	Тэтгэмжийн даатгал	9,787,800.00	12,521,464.94
210203	ҮОМШӨ-ийн даатгал	7,830,200.00	10,032,852.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,957,500.00	2,369,440.20
210205	Эрүүл мэндийн даатгал	19,168,452.00	23,858,831.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>186,910,050.71</b>	<b>224,056,431.24</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,025,488.00	14,922,091.50
210302	Түлш, халаалт	166,763,295.71	166,280,910.40
210303	Цэвэр, бохир ус	11,121,267.00	42,853,429.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,406,542.00</b>	-
210401	Бичиг хэрэг	1,447,010.00	
210402	Тээвэр, шатахуун	1,177,040.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,722,040.00	
210404	Ном, хэвлэл	830,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,073,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,156,652.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,594,961.10</b>	<b>30,554,930.40</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,208,930.00	
210502	Хоол, хүнс	32,640,231.10	30,554,930.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,745,800.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,613,405.00</b>	<b>11,054,945.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засвар	3,613,405.00	11,054,945.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>506,500.00</b>	
210702	Дотоод албан томилолт	506,500.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,571,090.00</b>	<b>17,945,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,419,090.00	4,746,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		13,199,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>114,201,927.02</b>	<b>177,372,073.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	347,650.00	69,961,111.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,725,500.00	10,517,976.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,128,777.02	96,892,986.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,103,653.41</b>	<b>131,447,321.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,337,298.00</b>	<b>131,447,321.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,637,298.00	114,288,321.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	17,159,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,766,355.41</b>	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,766,355.41	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(70,438,055.46)</b>	<b>4,240,428,573.06</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		

<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,960,546.00</b>	<b>2,593,930.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,960,546.00	2,593,930.00
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (IV)=(145-225)</b>	<b>(1,960,546.00)</b>	<b>(2,593,930.00)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (V)=(III)+(IV)</b>	<b>(72,398,601.46)</b>	<b>4,237,834,643.06</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,412,171,737.71</b>	<b>2,013,627,665.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,102,870.00</b>	<b>7,334,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,102,870.00</b>	<b>7,334,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,102,870.00</b>	<b>7,334,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,746,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,588,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	-
122001	Хандив тусламж /дотоод/		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,411,068,867.71</b>	<b>2,006,293,665.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,201,799,300.00</b>	<b>1,732,629,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,201,799,300.00	1,732,629,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,913,917.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,753,917.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>187,355,650.71</b>	<b>273,663,865.00</b>
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	187,355,650.71	273,663,865.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,411,068,867.71</b>	<b>1,874,600,404.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,411,068,867.71</b>	<b>1,874,600,404.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,368,391,212.30</b>	<b>1,740,378,804.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>964,800,464.59</b>	<b>1,246,400,275.02</b>
210101	Үндсэн цалин	620,853,185.48	957,850,977.26
210102	Нэмэгдэл	276,114,925.58	248,650,849.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	67,832,353.53	39,898,448.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,210,607.00</b>	<b>156,227,640.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	90,059,507.00	107,445,051.72
210202	Тэтгэмжийн даатгал	9,787,800.00	12,521,464.94
210203	ҮОМШӨ-ийн даатгал	7,830,200.00	10,017,252.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,957,500.00	2,385,040.20
210205	Эрүүл мэндийн даатгал	19,575,600.00	23,858,831.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>186,910,050.71</b>	<b>204,614,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,025,488.00	14,922,091.50

210302	Түлш, халаалт	166,763,295.71	166,280,910.40
210303	Цэвэр, бохир ус	11,121,267.00	23,411,398.10
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,701,200.00</b>	
210401	Бичиг хэрэг	1,495,620.00	
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,722,040.00	
210404	Ном, хэвлэл	830,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,038,400.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,814,840.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,670,200.00</b>	<b>30,547,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,265,300.00	
210502	Хоол, хүнс	18,553,400.00	30,547,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,851,500.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,277,900.00</b>	<b>27,844,100.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	18,100,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засвар	12,177,900.00	27,844,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>506,500.00</b>	
210702	Дотоод албан томилолт	506,500.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,566,090.00</b>	<b>17,945,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,414,090.00	4,746,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		13,199,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,748,200.00</b>	<b>56,800,089.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		37,049,689.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,748,200.00	19,750,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,677,655.41</b>	<b>134,221,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,911,300.00</b>	<b>134,221,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,211,300.00	117,062,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	17,159,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,766,355.41</b>	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,766,355.41	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,102,870.00</b>	<b>139,027,260.67</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>54,189,400.00</b>
<b>22</b>	<b>Биет ба биет бус хөрөнгө худалдан авах</b>		<b>54,189,400.00</b>
	Дотоод эх үүсвэрээс		54,189,400.00
223001	Бусад хөрөнгө		54,189,400.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>(54,189,400.00)</b>

VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,102,870.00</b>	<b>84,837,860.67</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		84,837,860.67

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ ний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,000,000.00</b>		<b>4,220,234,654.92</b>	<b>4,231,234,654.92</b>
Тайлант үеийн үр дүн			(72,398,601.46)	(72,398,601.46)
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,000,000.00</b>	-	<b>4,147,836,053.46</b>	<b>4,158,836,053.46</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-4,061,943,066.47	-4,061,943,066.47
Тайлант үеийн үр дүн			4,237,834,643.06	4,237,834,643.06
<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>11,000,000.00</b>	-	<b>4,323,727,630.05</b>	<b>4,334,727,630.05</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,013,592,800.00</b>	<b>1,928,789,804.33</b>	<b>84,802,995.67</b>	<b>95.8</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,013,592,800.00</b>	<b>1,928,789,804.33</b>	<b>84,802,995.67</b>	<b>95.8</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,871,784,900.00</b>	<b>1,794,568,204.33</b>	<b>77,216,695.67</b>	<b>95.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,293,294,000.00</b>	<b>1,246,400,275.02</b>	<b>46,893,724.98</b>	<b>96.4</b>
Үндсэн цалин	960,482,900.00	957,850,977.26	2,631,922.74	99.7
Нэмэгдэл	295,910,600.00	248,650,849.60	47,259,750.40	84.0
Урамшуулал	36,900,500.00	39,898,448.16	(2,997,948.16)	108.1
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>161,627,800.00</b>	<b>156,227,640.31</b>	<b>5,400,159.69</b>	<b>96.7</b>
Тэтгэврийн даатгал	109,418,600.00	107,445,051.72	1,973,548.28	98.2
Тэтгэмжийн даатгал	12,955,100.00	12,521,464.94	433,635.06	96.6
ҮОМШӨ-ийн даатгал	10,539,000.00	10,017,252.12	521,747.88	95.0
Ажилгүйдлийн даатгал	2,610,400.00	2,385,040.20	225,359.80	91.4
Эрүүл мэндийн даатгал	26,104,700.00	23,858,831.33	2,245,868.67	91.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>204,614,400.00</b>	<b>204,614,400.00</b>	-	<b>100.0</b>
Гэрэл, цахилгаан	11,198,800.00	14,922,091.50	(3,723,291.50)	133.2
Түлш, халаалт	160,514,600.00	166,280,910.40	(5,766,310.40)	103.6
Цэвэр, бохир ус	32,901,000.00	23,411,398.10	9,489,601.90	71.2
<b>Нормативт зардал</b>	<b>39,202,200.00</b>	<b>30,547,100.00</b>	<b>8,655,100.00</b>	<b>77.9</b>

Хоол, хүнс	39,202,200.00	30,547,100.00	8,655,100.00	77.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27,844,100.00</b>	<b>27,844,100.00</b>	-	<b>100.0</b>
Урсгал засвар	27,844,100.00	27,844,100.00	-	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>			-	
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,945,200.00</b>	<b>17,945,200.00</b>	-	<b>100.0</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,746,000.00	4,746,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,199,200.00	13,199,200.00	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,257,200.00</b>	<b>110,989,489.00</b>	<b>16,267,711.00</b>	<b>87.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	107,458,400.00	92,036,689.00	15,421,711.00	85.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,798,800.00	18,952,800.00	846,000.00	95.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>141,807,900.00</b>	<b>134,221,600.00</b>	<b>7,586,300.00</b>	<b>94.6</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>141,807,900.00</b>	<b>134,221,600.00</b>	<b>7,586,300.00</b>	<b>94.6</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,648,900.00	117,062,600.00	7,586,300.00	93.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,159,000.00	17,159,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,013,592,665.00</b>	<b>2,013,627,665.00</b>	<b>(35,000.00)</b>	<b>100.0</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,732,629,800.00</b>	<b>1,732,629,800.00</b>	-	<b>100.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,732,629,800.00	1,732,629,800.00	-	100.0
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>273,663,865.00</b>	<b>273,663,865.00</b>	-	<b>100.0</b>
Орон нутгийн төсвөөс	273,663,865.00	273,663,865.00	-	100.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,299,000.00</b>	<b>7,334,000.00</b>	<b>(35,000.00)</b>	<b>100.5</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,746,000.00	4,746,000.00	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,553,000.00	2,588,000.00	(35,000.00)	101.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		84,837,860.67		
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>85</b>	<b>85</b>		
Удирдах ажилтан	5	5		
Гүйцэтгэх ажилтан	54	54		
Үйлчлэх	26	26		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Хүүхдийн сэтгэлийг ойлгон дэмждэг, хариуцлагатай, мэдлэг чадвар, ёс суртахуунаараа үлгэрлэсэн хамт олон байна” гэсэн эрхэм зорилгыг тавин ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Тодорхой зорилготой бие хүн төлөвшихөд дэмжлэг болох
- Бие даан сурах, хөдөлмөрлөх чадварыг хөгжүүлэх
- Асуудлыг шийдвэрлэх чадвар эзэмшүүлэх
- Тууштай, шударга, үнэнч байхад чиглүүлэх
- Мэдлэг, чадвараа бусадтай хуваалцах нөхцөл бүрдүүлэх

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,

- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 224,727.2 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		84,837.9	84,837.9
Авлага		975.7	975.7
Бараа материал	42,089.9	42,568.5	478.6
Үндсэн хөрөнгө	4,116,746.1	4,225,787.5	109,041.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,158,836.0</b>	<b>4,354,169.6</b>	<b>195,333.6</b>
Өр төлбөр		19,442.0	19,442.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,158,836.0	4,334,727.6	175,891.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,158,836.0</b>	<b>4,354,169.6</b>	<b>195,333.6</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 84,837.9 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,568.5 мянган төгрөг болж 478.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 194,222.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан ба үнэ төлбөргүйгээр 7,877.9 мянган төгрөгийн аж ахуйн болон бусад хангамжийн материал бүртгэж, 201,621.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,225,787.5 мянган төгрөг болж 109,041.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 54,189.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, орон нутгийн төсвөөс 151,745.0 мянган төгрөгийн дээврийн засвар, тоног төхөөрөмж, ном хэрэгсэл шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд дулааны нэгжийн үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор 19,442.0 мянган төгрөгийн халаалтын өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,334,727.6 мянган төгрөг болж 175,891.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,479,193.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 310,618.6 мянган төгрөгийн нийт 1,789,812.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тооцоололд МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 107 тоот тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ хэмжээ”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 тоот тушаал “Төрийн орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ”-г тус тус шинэчлэн тогтоосны дагуу багш, ажилчдын цалинг нэмэгдүүлэн тооцсон, мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөвт зардлын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор зарим төсөвт зардлуудыг бууруулан тооцоолсон байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зарлагыг 223,780.7 мянган төгрөгөөр өсгөж 2,013,592.8 мянган төгрөгөөр баталжээ. Үүнд, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 79,979.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 4,746.0 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 73,028.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,969.4 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 17,398.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 38,659.0 мянган төгрөгөөр тус тус нэмсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,732,629.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 273,663.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 7,334.0 мянган төгрөг нийт 2,013,592.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,928,789.8 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал 45,951.5 мянган төгрөг, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зардал 14,990.0 мянган төгрөг, дотуур байрны хоолны зардал 8,655.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	204,614.4	204,614.4		100%
2	Нийтлэг үйлчилгээ	69,049.6	69,049.6		100%
3	Эрүүл мэндийг дэмжих	6,071.6	6,071.6		100%
4	Дотуур байрны хоол	39,202.2	30,547.1	8,655.1	77.9%
5	Дотуур байрны үйлчилгээ	27,033.0	25,432.6	1,600.4	94.1%
6	Үдийн цай хөтөлбөр	124,648.9	117,062.6	7,586.3	93.9%

7	Тоглонгоо хөгжүүлье үндэсний хөтөлбөр	2,518.0	2,518.0	-	100%
8	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	59,940.0	44,950.0	14,990.0	74.9%
9	Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	11,879.3	10,781.7	1,097.6	90.8%
10	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,320,820.3	1,274,868.8	45,951.5	100%
11	Байр ашиглалтын үйлчилгээ	5,279.7	5,236.6	43.1	99.2%
12	Сургалт семинар	2,639.8	2,586.2	53.6	97.9%
13	Сурах бичгийн түрээс	4,746.0	4,746.0		100%
14	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	135,150.0	130,324.6	4,825.4	94.3%
<b>Нийт дүн</b>		<b>2,013,592.8</b>	<b>1,928,789.8</b>	<b>84,803.0</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын ажил гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор С.Нандинзул гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ш.Ичинхорлоо, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,501,150.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 30,023.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 84,803.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 149 мэдээллийг байршуулахаас 139 мэдээлэл байршуулж, 10 мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл /Бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /Бүтэн жилээр/
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан /Бүтэн жилээр/
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Бүтэн жилээр/
- Санхүүгийн тайлан /Бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /Бүтэн жилээр/
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө /Бүтэн жилээр/
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /Бүтэн жилээр/
- Худалдан авах ажиллагааны тайлан /Бүтэн жилээр/
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /Бүтэн жилээр/.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 126 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 150,828.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,183.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж 2 өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,183.3	2	5,183.3	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>5,183.3</b>	<b>2</b>	<b>5,183.3</b>	<b>100%</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж,

- зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *“Чиглэл хүргүүлэх тухай”* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан *“Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан”* гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
  3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.
  4. Тус сургуулийн нягтлан бодогч Ч.Цэндмаагийн ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 30.0-45.0 хувиар тооцож олгосон боловч Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 1/643 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,595.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”*, 15.1.3: *“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 42,881.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, 975.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 41,905.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн 975.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 41,905.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн	1	975.7			1	975.7						
Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй	1	41,905.9					1	41,905.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>42,881.6</b>			<b>1</b>	<b>975.7</b>	<b>1</b>	<b>41,905.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл байршуулаагүй	10						10	
<b>Дүн</b>	<b>10</b>						<b>10</b>	